

# АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

## Нэг.Макро эдийн засаг

### Төсөв санхүү

Аймгийн төсөвт 4.2 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 105,7 хувьтай байгаа ба өнгөрсөн оноос орлого 10.3 хувиар нэмэгджээ.Татварын орлогын төлөвлөгөө 5,6 хувиар, татварын бус орлого 6,1 хувиар давж биелэсэн байна. Улсын төсвөөс орон нутгийн төсөвт 2,5 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Улс болон орон нутгийн төсвөөс 32.1 тэрбум төгрөгийн зарлага санхүүжилт хийсний 55.0 хувийг цалинд, 5.9 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 30.9 хувийг бараа үйлчилгээний зардалд, 4.4 хувийг татаас ба урсгал шилжүүлэгт, 3.8 хувийг хөрөнгийн зардалд зарцуулжээ.

Санхүүжилтийн 19.2 хувийг орон нутгийн төсвийн санхүүжилт эзэлж байна.

### Ажил эрхлэлт ба ажилгүйдэл

Аймгийн хүн амын 62.3 хувь буюу 69805 нь хөдөлмөрийн насны хүн байна.Үүний 47384 ажиллагсад, 2230 ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүд, 8323 нь бүртгэлгүй ажил эрхлээгүй хүн ам, 8029 нь суралцагсад , 3839 нь хөдөлмөрийн чадваргүй хүн ам байна.

Ажиллагсадыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл : 64.8 хувь нь ХАА-н салбарт, 9.4 хувь нь бөөний болон жижиглэн худалдаанд, 10.6 хувь нь төсөвт байгууллагад, 15.2 хувь нь бусад салбаруудад ажиллаж байна.Ажиллагсадын тоо өмнөх оныхоос 0.7 хувиар буурсан байна..

Сумдаас ирүүлсэн мэдээгээр хөдөлмөр эрхлэгч 515 хүүхэд байгаагийн 55.7 хувь нь ХАА-н салбарт, 26.0 хувь нь уул уурхайн салбарт, 18.3 хувь нь албан бус секторт хөдөлмөр эрхэлж байна.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэст 2230 хүн ажил хайж бүртгүүлсний 51.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Бүртгүүлсэн ажилгүйчүүд өнгөрсөн онтой харьцуулахад 13.2 хувиар буурсан ба 32.9 хувь нь 25-34 насныхан, 26.5 хувь нь 35-44 насныхан, 28.3 хувь нь 16-24 насныхан, 12.3 хувь нь 45-60 насныхан , 49.7 хувь нь урьд нь ажил эрхэлж байсан, 50.3 хувь нь анх удаа ажил эрж байгаа хүмүүс байна.

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 29.9 хувь нь бүрэн дунд, 14.5 хувь нь дээд, 31.3 хувь нь бүрэн бус дунд, 4.3 хувь нь тусгай дунд, 10.4 хувь нь мэргэжлийн анхан шатны, 8.3 хувь нь бага боловсролтой байна.

Энэ онд аймгийн хэмжээнд 1726 байнгын ажлын байр шинээр бий болсон байна.

Ажлын байраар хангагдагсдын 8.7 хувь нь барилгад, 21.4 хувь нь хөдөө аж ахуйд, 7.2 хувь нь үйлдвэрлэлд, 15.0 хувь нь зочид буудал зоогийн газарт, 13.5 хувь нь бөөний болон жижиглэн худалдаанд , 1.7 хувь нь тээвэр, холбоонд, 7.5 хувь нь уул уурхайд, 8.1 төсөвт байгууллага 8.0 хувь нь хувийн үйлчилгээ эрхлэх чиглэлээр, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд ажлын байртай болжээ.

### Үнэ

2010 оны эцсийн байдлаар хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тарифын индекс 2009 оныхоос 13.6 хувиар , өмнөх 11 сартай харьцуулахад 1.8 хувиар тус тус өссөн байна.

Өрхийн хэрэглээний 40.0 гаруй хувийг эзэлдэг хүнсний барааны үнийн өсөлт нь үнийн ерөнхий өсөлтөд шууд нөлөөлдөг.

2010 онд хүнсний барааны бүлгийн индекс өмнөх онтой харьцуулахад 28.4 хувиар, хувцас гутал бөс бараанд 4.2 хувиар, орон сууцанд 1.7 хувиар, гэр ахуйн бараанд 2.9 хувиар, эм тариа эмнэлгийн үйлчилгээнд 10.8 хувиар, соёл боловсролын үйлчилгээнд 0.4 хувиар, бусад бараа үйлчилгээнд 0.2 хувиар нэмэгдсэн байна.

#### Банк, мөнгө, зээл

Иргэд, байгууллагын мөнгөн хадгаламж 24.2 тэрбум төгрөг болж аймгийн нэг хүнд дунджаар 215.7 мян. төгрөгийн, нэг хадгаламж эзэмшигчид 707.0 мян. төгрөгийн хадгаламж ногдож байна. Өнгөрсөн оноос хадгаламж эзэмшигчийн тоо 23.4 хувиар, хадгаламж 29.1 хувиар өсчээ.

Арилжааны банкуудын дүнгээр 22055 иргэд, аж ахуйн нэгжид 51.8 тэрбум төгрөгийн зээл олгосон нь өнгөрсөн оноос зээлдэгчдийн тоо 14.6 хувиар буурч, олгосон зээлийн хэмжээ 1.2 хувиар өсчээ. Оны эцэст зээлийн өрийн үлдэгдэл 36.1 тэрбум төгрөг байгаа ба хугацаа хэтэрсэн зээл 0.4 хувь буюу 131.7 сая.төгрөг, чанаргүй зээл 3.2 хувь буюу 1.1 тэрбум.төгрөг байна.

Банкуудын төгрөгийн хугацаагүй хадгаламжийн жилийн хүү 6.0-8.4 хувь, хугацаатай хадгаламжийн жилийн хүү 10.5-19.9 хувьтай байна.

#### **Хоёр. Нийгмийн үзүүлэлт**

##### Хүн ам

Өвөрхангай аймгийн суурин хүн амын тоо жилийн эцсийн байдлаар 112.1 мянга болж өмнөх онохоос 0.1 хувь буюу 143 хүнээр өссөн байна.

Нийт хүн амын 49.6 хувь нь эрэгтэйчүүд, 50.4 хувь нь эмэгтэйчүүд байгаа бөгөөд 100 эмэгтэйд 98 эрэгтэй ногдож байна. Аймгийн хүн амын хүйсийн харьцаа 49.6х 50.4 байна.

Нийт хүн амын 64.4 хувь нь залуу болон идэр насныхан, 29.5 хувь нь хүүхдүүд, 6.1 хувь нь хөгшид байна.

Өрх 32.5 мянгад хүрч, өнгөрсөн оноос 0.3 хувь буюу 102 өрхөөр нэмэгджээ. Нийт өрхийн 22.6 хувь нь аймгийн төвд, 26.4 хувь нь сумын төвд, 51.0 хувь нь хөдөөд, нийт хүн амын 23.0 хувь нь аймгийн төвд, 26.6 хувь нь сумдын төвд, 50.4 хувь нь хөдөө суурьшсан байна.

##### Хүн амын ердийн хөдөлгөөн

Төрсөн 2714 хүүхдийг иргэний бүртгэлд бүртгэн, нас барсан 752 хүнийг иргэний бүртгэлээс хасч, 301 хос гэрлэлтээ бүртгүүлж, 72 гэр бүл гэрлэлтийг цуцалж, 160 хүүхэд үрчлэгдсэн байна.

Бүртгүүлсэн гэр бүлийн 68.4 хувь тайлант онд гэрлэжээ. Гэрлэсэн эрэгтэйчүүдийн 38.5 хувь нь 20-24 насныхан, 28.9 хувь нь 25-29 насныхан, 2.3 хувь нь 18-19 насныхан эмэгтэйчүүдийн 42.5 хувь нь 20-24 насныхан, 7.6 хувь нь 18-19 насныхан байна.

Нийт гэр бүл цуцлалтын 11.1 хувь 7-9 жил гэр бүл байсан, үрчлэлтийн 35.0 хувь 3 хүртэл насны хүүхэд байна.

ИБМА-ны мэдээгээр тайлант жилд 3785 хүн шилжин явж, 2076 хүн шилжин иржээ. Шилжин ирэгсдийн 66.4 хувийг аймаг дотроо сумаас суманд шилжигсэд, 33.6 хувийг УБ хот болон бусад аймгуудаас шилжин ирэгсэд эзэлж байна.

Шилжин явагсдын 61.0 хувь нь Улаанбаатар болон бусад аймаг руу шилжин явсан ба 73.4 хувь нь хөдөлмөрийн насны хүн байна..

#### Хүн амын эмзэг бүлэг

Сумдуудын өөрсдийнх нь тодорхойлж ирүүлсэн мэдээгээр амьжиргааны баталгаажих доод төвшнөөс доогуур орлоготой 8633 өрхөд 34.2 мянган хүн амьдарч байгаа нь нийт өрхийн 26.6, нийт хүн амын 30.5 хувийг тус тус эзэлж байна.

Амьжиргааны баталгаажих доод түвшнээс доогуур орлоготой өрхийн 30.8 хувь нь нэн ядуу өрх байна.

2010 оны байдлаар Хангайн бүсийн хэмжээнд амьжиргааны баталгаажих доод түвшин 91500 төгрөг байна.

Аймгийн хэмжээнд 194 бүтэн өнчин, 1642 хагас өнчин хүүхэд, хүүхэдтэй гэр бүлгүй хүн 2123, өрх толгойлсон эмэгтэйчүүд 2856 байна. Нийт өрхийн 8.8 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүлэгчтэй байна.

#### Нийгмийн халамж, даатгал

Аймгийн дүнгээр давхардсан тоогоор 136.9 мянган хүнд 15.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон байна. 2440 хүнд 1212.0 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, 2565 хүнд 598.5 сая төгрөгийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламж дэмжлэг шаардлагатай 2159 хүнд 251.6 сая. төгрөгийн тэтгэмж, тусламж, 7360 ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд 466.8 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлт, Хүний хөгжил сангаас 110764 хүнд 10.9 тэрбум төгрөг олгожээ.

Нийгмийн даатгалын сангийн орлогод 17.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөө 102.1 хувиар биелэн өнгөрсөн оноос сангийн нийт орлого 10.2 хувиар өссөн байна. Нийгмийн даатгалын сайн дурын орлого 102.3 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 101.1 хувь, эрүүл мэндийн даатгалын хураамж 126.4 хувь, тус тус биелжээ. Бүх төрлийн тэтгэвэр авагч 13358 хүнд 13.9 тэр.бум төгрөгийн тэтгэвэр, 2133 хүнд 565.3 сая.төгрөгийн тэтгэмж олгосон байна.

#### Боловсрол

2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 30 сургуулийн 757 бүлэгт 22.8 мянган хүүхэд суралцаж, 31 цэцэрлэгийн 112 бүлэгт 3.5 мянган хүүхэд хүмүүжиж, эдгээрт 1331 багш сурган хүмүүжүүлэгч ажиллаж байна. Өнгөрсөн оноос суралцагсад 3.7 хувиар буурч, хүмүүжиж байгаа хүүхэд 11.2 хувиар өсч, багш сурган хүмүүжүүлэгч 0.7 хувиар нэмэгджээ.

2009-2010 оны хичээлийн жилд 3675 хүүхэд 9, 11-р ангийг төгссөнөөс 63.2 хувь нь суурь боловсролыг, 36.8 хувь нь бүрэн дунд боловсролыг эзэмшсэн байна.

СӨБоловсролд хамрагдвал зохих хүүхдийн (2-5 насны) 73,7 хувь нь хамрагдсан байна.

#### Эрүүл мэнд

Эмнэлгүүдэд 2752 эх амаржиж , 712 хүн нас барж, өнгөрсөн оноос төрөлт 6.5 хувиар буурч, нас баралт 6.6 хувиар нэмэгдсэн байна. Нас баралтын 10.9 хувийг нялхсын нас баралт эзэлж байгаа ба энэ нь өнгөрсөн

оноос 14.7 хувиар өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 24.5 , нас баралт 6.4 байна.

Халдварт өвчнөөр өвчилсөн 1054 тохиолдол гарсан нь өнгөрсөн оноос 5.8 хувиар өссөн байна. Нийт өвчлөлтийн 35.3 хувийг халдварт шар, 8.3 хувийг сүрьеэ, 12.7 хувийг заг хүйтнээр өвчлөгсөд эзэлж байна.

#### Сахилга дэг журам

Цагдаагийн газрын мэдээгээр 439 хэрэгт 472 хүн холбогдон шалгагдаж, эзэн холбогдогч нь тогтоогдоогүй 35 хэрэг байна. Өмнөх оноос бүртгэгдсэн хэрэг 23.7 хувиар, холбогдогч 22.6 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн хэргийн 34.9 хувь нь иргэдийн өмчийн хулгай, 29.0 хувь нь ИЭЧЭМЭ хэрэг, 4.6 хувь нь танхай, 8.0 бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэрэг байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 571.3 сая төгрөгийн хохирол учирч, 86 хүн нас барсан ба нийт хохирлын 50.1 хувийг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт холбогдсон 472 хүний 36.0 хувь нь эрхэлсэн ажил хөдөлмөргүй, 32.0 хувь нь бүлэглэн, 43.6 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн ба 66.1 хувь нь 18-35 хүртэл насны хүмүүс байна.

### **Гурав. Үйлдвэрлэл үйлчилгээний салбар.**

#### Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт 5973.5 сая. төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, оны үнээр 5619.2 төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх оноос үйлдвэрлэлт 28.5 хувиар, борлуулалт 29.0 хувиар өссөн байна.

Нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн 40.1 хувийг хүнсний салбарт, 19.2 хувийг цахилгаан, дулааны үйлдвэрлэлийн салбарт, 23.1 хувийг мод модон эдлэлийн үйлдвэрлэлт, 11.8 хувийг уул уурхайн салбарт, 5.8 хувийг бусад жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлийн салбаруудад тус тус үйлдвэрлэжээ.

13.4 хувийг архи , 5.4 хувийг гурил, 5.3 хувийг сүү, тараг, ааруул, 3.2 хувийг цэвэр ус, зайрмаг үйлдвэрлэлт тус тус эзэлж байна.

#### Хөдөө аж ахуй

2010 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр малын тоо 2010.6 мянган толгойд хүрч 1609.6 мян.толгойгоор буурсан дотор тэмээ 14.7 мянга, адуу 113.8 мянга, үхэр 76.2 мянга, хонь 896.6 мянга, ямаа 909.2 мянга болж, тэмээ 465 толгойгоор, адуу 69619 толгойгоор, үхэр 64823 толгой, хонь 794818 толгойгоор, ямаа 679893 толгойгоор тус тус буурсан байна.

Малтай өрх 17974, үүнээс нь малчин өрх 15536 байна. Эдгээр өрхийн тоо 2009 оныхоос малтай өрх 9.6 хувиар, малчин өрх 7.8 хувиар тус тус буурсан байна. Аймгийн нэг малтай өрхөд 111.9 нэг малчин өрхөд 129.4 толгой мал ноогдож байна.

1000 ба түүнээс дээш малтай 82 өрх байгаа нь өмнөх оныхоос 63.1 хувиар буурсан байна.

Оны эхний малын 153.3 мянган толгой малыг зах зээлд худалдан борлуулж, 215.3 мянган толгой малыг хүнсэнд хэрэглэж, 159.9 мянган толгой малыг бусдад шилжүүлсэн байна.

Нийт 933.3 мянган хээлтэгч мал тоологдсон нь нийт малын 46.4 хувийг эзэлж , өнгөрсөн оноос хээлтэгчийн тоо 34.9 хувиар буюу 500.9 мянган толгойгоор буурч нийт малд эзлэх хувийн жин 1.0 пунктээр өссөн байна.

16913 толгой хээлтүүлэгчийн 61.3 хувийг хуц, ухна эзэлж байна. Нэг хээлтүүлэгчид 23 ингэ , 6 гүү, 29 үнээ, 75 эм хонь, 94 эм ямаа ногдож байгаа нь үржлийн нормт хэмжээнээс ингэ, гүү доогуур, эм хонь, эм ямаа нормын түвшинд байна.

Аж ахуй нэгж байгууллагууд 2128 толгой мал тоолуулсан байна.

Цэвэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 232.2 мян. мал тоологдсоны 8.4 хувь буюу 19478 нь цэвэр үүлдэр, 91.6 хувь буюу 212696 нь эрлийз үүлдрийн мал байна.

Аймгийн дүнгээр 113 гахай, 1 илжиг, 1511 тахиа тоологдсон байна

Оны эхний төллөх эх малын 41.2 хувь буюу 575.8 мянган эх мал төллөж гарсан төлийн 51.6 хувь буюу 298.1 мянган төлийг бойжуулсан байна.

Оны эхний нийт малын 46.0 хувь буюу 1664338 толгой мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оноос 12 дахин өссөн байна. Нийт хорогдлын 90.4 хувийг бог мал эзэлж байна. Хорогдсон малын 0.2 хувь буюу 2616 нь өвчнөөр хорогдсон байна.

Аймгийн хэмжээнд энэ онд шинээр 59 худаг гаргаж, 60 худаг засварласан байна.

Аймгийн дүнгээр хаврын тариалалтаар 1716.7 га-д үр тариа, 281.2 га-д төмс, 142.2 га-д хүнсний ногоо тариалж, намрын ургац хураалтаар 1396.7 га-аас 1088.5 тн үр тариа , 280.9 га-аас 2655 тн төмс , 139.2 га-аас 1458.5 тн хүнсний ногоо хураан авчээ. Өнгөрсөн оноос үр тариа 386.5 тн-оор , төмс 263.0 тн-оор , хүнсний ногоо 12.1 тн-оор тус тус өссөн байна.

Аж ахуйн нэгж, иргэд 31346.1 тн хадлан, 5330.2 тн гар тэжээл бэлтгэжээ.

#### Хөрөнгө оруулалт ,Барилга

2010 онд Эдийн засаг , нийгмийн хөгжилд 21.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээс 52.8 хувь буюу 11.5 тэрбум нь улсын төсвийн хөрөнгө, 2.0 хувь буюу 0.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь орон нутгийн төсвийн хөрөнгөөр, 21.0 хувь буюу 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь нь гадаадын хөрөнгө оруулалт, 24.1 хувь буюу 5.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь банкны зээл болон сумын өөрийн хөрөнгө, иргэдийн хөрөнгөөр тус тус санхүүжигдсэн байна.

Хөрөнгө оруулалтын ажлын 59.2 хувийг барилга угсралт, их засварын ажилд, 19.7 хувийг зам засвар, арчлалтад, 7.7 хувийг худаг гаргах болон гэрэлтүүлэг, дулааны шугам засварт, 13.4 хувийг бусад үйл ажиллагаануудад зарцуулсан байна.

Барилгын гүйцэтгэгч байгууллагууд 12.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг 101 объектод хийж гүйцэтгэсний 11.5 хувь буюу 1.5 тэрбум төгрөг нь их засварын ажил байна. Өнгөрсөн оноос гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын хэмжээ 2.2 дахин өсч , их засварын ажил 51.6 хувиар буурчээ. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 23 объектод 0.6 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн нь өнгөрсөн оноос 53.8 хувиар буурсан байна.

#### Тээвэр, холбоо

Тээврийн байгууллагууд 28.3 мянган тн ачаа тээвэрлэн, 11.3 мян.тн/км-ийн ачаа эргэлт, 163.2 мянган зорчигч тээвэрлэн, 41.8 мян. хүн/км-ийн зорчигч эргэлт хийж, тээврийн үйлчилгээнээс 1329.1 сая.төгрөгийн орлоготой ажиллажээ.Өнгөрсөн оноос орлого 38.2 хувиар нэмэгдсэн байна.

Зорчигч тээврийн үйлчилгээнд 8 автобус, 138 микроавтобус, 49 такси гарч тэдгээрт 34 хүн ажилласан байна.

Холбооны байгууллагууд 280.3 сая. төгрөгийн орлоготой ажилласны 20.0 хувийг хүн амын үйлчилгээний орлого эзэлж байна.Өнгөрсөн оноос нийт орлого 6.0 хувиар буюу 18.0 сая.төгрөгөөр буурчээ.

Интернетээр үйлчлүүлэгчдийн тоо 5843 болж өнгөрсөн оныхоос 12.5 хувиар өссөн ба 89.0 сая.төгрөгийн орлоготой ажилласан байна.

Аймгийн хэмжээнд үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 52.1 мянга болж өнгөрсөн оныхоос 18.3 хувиар өссөн байна..

#### Худалдаа, үйлчилгээ

Аймгийн худалдаа , нийтийн хоолны цэг салбарууд 24.0 тэрбум төгрөгийн бараа гүйлгээ хийсэн нь өмнөх оноос 8.6 хувиар өссөн байна.

Өнгөрсөн оноос цайны газар, эм борлуулалт, бар ресторан, авто засвар, шатахуун борлуулалт, барааны дэлгүүр, барилгын материалын дэлгүүр, хүнсний дэлгүүр, авто сэлбэгийн дэлгүүрийн орлого 1.0-27.9 хувиар өсчээ.

#### Орон сууц

Энэ онд иргэдийн өөрийн хөрөнгөөр 12988.6 м.кв ашигтай талбай бүхий 187 хувийн өмчийн орон сууц ашиглалтанд оржээ. Эдгээр сууцанд 572 хүн оршин сууж, амьдарч байна.

Эдгээрт иргэдийн амины зориулалтаар барьсан хувийн, энгийн галлагаатай байшингууд хамрагдсан болно.

#### Бусад мэдээлэл.

Аймгийн татварын албанд бүртгэлтэй аж ахуйн нэгжийн тоо 923 байгаагийн төсөвт байгууллага 192, ХК 17, ХХК 403, салбарууд 90, хоршоо 64, ЗБН, ББН 78, төрийн бус байгууллага 3624, ОНБайгууллага 15, хадгаламж зээлийн хоршоо 13 , шашны байгууллага 8 байна.

Аймгийн хэмжээнд 16 сүм хийд үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээрт 222 хүн ажилладгаас 168 нь хурлын лам нар байна.

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС